



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 0/02

Ховд

Бүтэц, орон тоо шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолын 2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2016 оны А/421 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог 1 дүгээр хавсралтаар, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасаг, Нутгийн удирдлагын ордны үйлчилгээний тасаг, Засаг даргын Тамгын газрын үйлчилгээний ажилтнуудын бүтэц, орон тоог 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Төрийн албаны шинэчлэсэн хууль мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан төрийн захиргааны албан хаагч нартай гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хийж дуусгахыг хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Чиг үүрэгт нь өөрчлөлт орсон хэлтсүүдийн дүрмийг шинэчлэн батлуулж, холбогдох мэргэжилтнүүдийн ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын зорилго, зорилт, хэтийн төлөвлөгөө, мэргэжилтнүүдийн ажлын чиг үүрэг /зорилго, зорилт/-тэй нягт уялдуулан 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор шинэчлэн батлуулж, мөрдүүлэн ажиллахыг тухайн хэлтсийн дарга нарт даалгасугай.

4. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн болон Нутгийн удирдлагын ордны үйлчилгээний тасгийн дүрмийг 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор шинээр боловсруулан батлуулж, ажилчдын хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулж, хэрэгжилтэнд нь хяналт тавьж, үйлчилгээний ажлын үр дүнг эрс сайжруулж ажиллахыг дээрх тасгийн дарга нарт үүрэг болгосугай.

5.Тус тушаал гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 31-ний А/195 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


6. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Б.Ганболд/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2019 оны 01 дүгээр сарын 08-ны
өдрийн А/02 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт




АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ,
ОРОН ТОО

Д/Д	Албан тушаал	Албан тушаалын зэрэглэл
Удирдах бүрэлдэхүүн-3		
1.	Аймгийн Засаг дарга-1	УТ
2.	Аймгийн Засаг даргын орлогч-2	УТ
Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, бүрэлдэхүүн-41		
3.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга-1	ТЗ-11-5
1. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс-8		
4.	Хэлтсийн дарга-1	ТЗ-9-4
5.	Сум, байгууллагын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн-1	ТЗ-6-3
6.	Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн-1	ТЗ-5-1
7.	Иргэдийн өргөдөл, гомдол, эрэлт хүсэлтийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн-1	ТЗ-6-5
8.	Гадаад харилцааны асуудал хариуцсан мэргэжилтэн-1	ТЗ-5-1
9.	Засаг даргын Тамгын газрын дотоод ажил, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн-1	ТЗ-5-5
10.	Төлөвлөлт, зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн-1	ТЗ-5-4
11.	Цахим засаглал, мэдээллийн технологи, сүлжээний асуудал хариуцсан мэргэжилтэн-1	ТЗ-5-2
2. Хууль, эрх зүйн хэлтэс /Архивын тасагтай/-4		
12.	Хэлтсийн дарга-1	ТЗ-9-2
13.	Авлигын эсрэг үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн-1	ТЗ-6-3
14.	Эрх зүйн сургалт, сурталчилгаа, хууль тогтоомжийн лавлагаа, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн-1	ТЗ-5-3
15.	Гэрээ болон дотоод ажил хариуцсан мэргэжилтэн-1	ТЗ-5-1
16.	Архивын тасгийн дарга-1	ТЗ-7-2
3. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлийн хэлтэс-8		
17.	Хэлтсийн дарга-1	ТЗ-9-5
18.	Барилга хот байгуулалт, газрын харилцаа, инженерийн шугам сүлжээний асуудал хариуцсан мэргэжилтэн-1	ТЗ-6-1
19.	Эдийн засаг, стратеги төлөвлөлт, хөрөнгө оруулалтын асуудал асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн-1	ТЗ-5-1
20.	Хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн-1	ТЗ-5-2
21.	Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн-1	ТЗ-5-5
22.	Зам тээвэр, уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн-1	ТЗ-5-1
23.	Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтэн-1	ТЗ-5-2

3.Нийгмийн бодлогын хэлтэс-5		
24.	Хэлтсийн дарга-1	T3-9-3
25.	Эрүүл мэндийн асуудал асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн-1	T3-6-5
26.	Боловсрол, шинжлэх ухааны асуудал хариуцсан мэргэжилтэн-1	T3-5-4
27.	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, гэр бүл, хүүхэд залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн-1	T3-5-3
28.	Соёл, урлаг, биеийн тамир, спортын асуудал хариуцсан мэргэжилтэн-1	T3-5-3
4. Санхүү, төрийн сангийн хэлтэс-8		
29.	Хэлтсийн дарга-1	T3-9-5
30.	Төсвийн зарлагын мэргэжилтэн-1	T3-5-4
31.	Төсвийн орлого, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн-1	T3-5-1
32.	Бүртгэлийн мэргэжилтэн-1	T3-6-5
33.	Төсвийн ерөнхий нягтлан бодогч-1	T3-8-5
34.	Төрийн сангийн мэргэжилтэн-2	T3-5-1
35.	Төрийн сангийн дотоод хяналт, аудит хариуцсан ахлах мэргэжилтэн-1	T3-6-3
5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс-3		
36.	Хэлтсийн дарга-1	T3-9-3
37.	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн-1	T3-6-4
38.	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн-1	T3-5-3
6. Цэргийн штаб-4		
39.	Штабын дарга	ТТ-15
40.	Тоо бүртгэл эрхэлсэн офицер-1	ТТ-13
41.	Орон нутгийн хамгаалалт, сургалтын асуудал эрхэлсэн офицер-1	ТТ-13
42.	Дайчилгааны офицер-1	ТТ-13
НИИТ		41

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2019 оны 01 дүгээр сарын 08-ны
едрийн А/02 дугаар тушаалын
2 дугаар хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
САНХҮҮ, АЖ АХУЙН ТАСГИЙН БҮТЭЦ, ОРОН ТОО

Д/Д	Албан тушаал	Ангилал зэрэглэл
1.	Тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч-1	ТҮ-8
2.	Нягтлан бодогч-1	ТҮ-7
3.	Нярав-1	ТҮ-4
4.	Жолооч-8	ТҮ-3
5.	Харуул -4	ТҮ-1
6.	Сахиул-2	ТҮ-1
НИЙТ		17

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
НУТГИЙН УДИРДЛАГЫН ОРДОНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТАСГИЙН БҮТЭЦ, ОРОН ТОО

Д/Д	Албан тушаал	Ангилал зэрэглэл
1.	Тасгийн дарга-1	ТҮ-8
2.	Үйлчлэгч-10	ТҮ-1
3.	Сантехникийн слесарь-1	ТҮ-3
4.	Цахилгаанчин-1	ТҮ-3
НИЙТ		13

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНУУД

Д/Д	Албан тушаал	Ангилал зэрэглэл
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс-10		
1.	Бичиг хэргийн эрхлэгч-1	ТҮ-5
2.	Бичиг хэргийн оператор-2	ТҮ-2
3.	Засаг даргын туслах-1	ТҮ-4
4.	Засаг даргын зохион байгуулалтын асуудал харицсан шадар туслах-1	ТҮ-4
5.	Угтах үйлчилгээ, 7043-1111 төв хариуцсан ажилтан-1	ТҮ-2
6.	Засаг даргын Хэвлэлийн төлөөлөгч-3	ТҮ-6
Хууль эрх зүйн хэлтсийн Архивын тасаг-1		
7.	Сан хөмрөгийн эрхлэгч-1	ТҮ-6
НИЙТ		10